

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.ЭРДЭНЭТУЯА

2022 оны 11 сарын 23

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

2022 оны 11 дүгээр сарын 22

Баруун-Урт

1.Үндэслэл

Ажилтан сонгон шалгаруулах журам нь чадварлаг ажилтан авч ажиллуулах замаар байгууллагын ажиллах бүрэлдэхүүнийг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, байгууллагын хөгжил дэвшлийг хангах хүний нөөцийн ил тод байдалд нийцүүлэх, үйл ажиллагааг чанартай зохион явуулах зорилгоор үйлчилнэ.

Ажлаас чөлөөлөгдсөн ажилтны орон тоо нь сул чөлөөтэй үлдсэн, шинээр орон тоо бий болсон, ажилтны хөдөлмөрийн гэрээ дуусгавар болоогүй бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаанаар түүний ажил албан тушаал хадгалагдаж буй үед оронд нь түр хугацаагаар ажилтан авч ажиллуулахад тус тус энэхүү журмыг баримтална.

2.Сонгон шалгаруулалт явуулах журам.

2.1 Даргын тушаалаар сонгон шалгаруулалтын баг томилогдон ажлыг зохион явуулж эцсийн дүнг Даргад танилцуулж эцсийн шийдвэр гарна.

2.2 Байгууллагын үндсэн ажилтан холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжил дээшлүүлэх, захиргааны чөлөө авах зэргээр ажил албан тушаалаасаа түр хөндийрсөн үед эзгүй байгаа ажилтны сул орон тоон дээр иргэнийг авч ажиллуулахдаа Хүний нөөцөд бүртгэлтэй иргэдээс сонгон шалгаруулж ажиллуулна.

2.3.Сул чөлөөтэй буюу эзгүй байгаа ажилтны ажлын байрны талаарх мэдээллийг хүний нөөцийн мэргэжилтэн хариуцаж олон нийтэд нээлттэй зарлана.

2.4 Энэхүү журмыг хэрэгжүүлэхдээ ил тод, зөв шударга, нээлттэй байх зарчмыг баримтална

2.5. Шалгаруулалтын оноог дараах байдлаар үнэлнэ.Нийт 100 оноо

1. Өргөдлийн маягтын үнэлгээ /0-10 оноо/
2. Зан төлөвийн тест /0-30 оноо /
/1,2/ онооны нийлбэрээс шалтгаалан эхний 1-3 оролцогчийг дараагийн шатны шалгаруулалтад оруулах эрхийг үүсгэнэ.
3. Ярилцлага /0-50 оноо /

2.6 Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлээрээ ажиллаж байсан бөгөөд чадвартай эмч, эмнэлгийн ажилтанг шалгалтгүйгээр, гэхдээ баг өмнөх ажлын газрын тодорхойлолт, амжилттай нь танилцаж ярилцлага хийсний үндсэн дээр уг ажлын байранд авч ажиллуулж болно. Ажил горилогч иргэдээс сонгон шалгаруулалтыг доорх үйл ажиллагааны дагуу зохион байгуулж шатлал бүрд шалгаруулж онооны байдлаас харгалзан хасагдах байдлаар эцсийн дүн мэдээг Даргад танилцуулж шийдвэрийг гаргана.

3.Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үйл ажиллагаа

3.1.Бүрдүүлэлт хийх

- Ажлын байрны зараар ажиллах салбар, хэлбэр, сонгон шалгаруулах зарчим, хугацаа, давуу тал, бүрдүүлэх материал, бусад хангамж /зэргийг дэлгэрэнгүй мэдээлэх
- Сул ажлын байрны зарыг нийтэд дараах байдлаар түгээнэ.

- Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн сан
- Байгууллагын вэб болон facebook
- Их, дээд сургууль
- Хөдөлмөрийн яармаг
- Хүний нөөцөд бүртгүүлсэн

3.2 Өргөдлийн маягтаар мэдээллийг авч, дүгнэн хэлэлцэх

➤ Ажлын ур чадварт чиглэсэн өргөдлийн маягт бөглүүлэх

- Хувийн мэдээлэл
- Боловсролын байдал
- Мэргэжил дээшлүүлсэн байдал
- Тухай ажил үүрэгтэй холбоотой ажлын туршлага, бусад үйл ажиллагаа

3.3 Зан төлөвийн тест, чадамжийн тестийн шалгалт авах

- Зан төлөвийн тестийг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, санхүү, техникийн ажиллагсад, аж ахуйн тасгийн ажиллагсад, асрагч нараас авна.
- Зан төлөв, Чадамжийн тестийг хослуулан захиргааны ажиллагсад буюу тасгийн эрхлэгч нараас авна.

4. Аман ярилцлага хийх

4.1 Тухай ажил мэргэжлийн онцлогийг харгалзан ур чадварыг илэрхийлж болохуйц ярилцлагын асуултыг боловсруулж, дүгнэх хуудсыг урьдчилан бэлдсэн байна/

4.2 Ярилцлагыг нөхцөл байдалд суурилсан ярилцлага, туршлагад суурилсан ярилцлага гэсэн 2 төрлөөр явагдана.

4.3 Ярилцагч 1 хүнтэй ярилцах хугацаа 30 минут байна. Энэ хугацаанд 3-4 ур чадварыг тогтоосон байна.

5. Сонгон шалгаруулалтын баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.1. Сонгон шалгаруулалтад оролцох иргэдийг бүртгэх, материалыг хүлээн авах, хянах, нэгтгэх.

5.2. Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангаж, зохион явуулах.

5.3. Сонгон шалгаруулалтын дүнг хурлаараа хэлэлцэн, шалгаруулалтад оролцсон иргэдийн онооны жагсаалтыг гаргах.

5.4. Сонгон шалгаруулалтын дүнг оролцогчдод танилцуулах, тайланг бичиж Удирдлагын зөвлөлд танилцуулах, материалыг үдэж архивт өгөх.

5.5. Сонгон шалгаруулалттай холбоотой санал гомдлыг хүлээн авч, зохих журмын дагуу шийдвэрлэх.

6. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага.

6.1. Сонгон шалгаруулалт явуулах багт орсон ажилтан нь шалгалтын материалын нууцыг задруулах, оролцогчдод хооронд нь хов живийн чанартай мэдээлэл өгөх, тэднээс бэлэг авах, дээрх журмын заалтуудыг илт зөрчсөн үйлдэл хийх зэргээр зөрчил гаргасан нь нотлогдсон тохиолдолд хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн тухай хуулийн дагуу ноцтой зөрчилд тооцон хариуцлага хүлээлгэнэ.

7. Шалгаруулалтад орох иргэний хүлээх үүрэг хариуцлага.

7.1 Баримт бичгийн шалгалтад шаардагдах боловсролын баримт бичгийг нотариатаар баталгаажуулсан хуулбар, иргэний үнэмлэхний хуулбар, НДД-ийн хуулбар зэргийг үнэн зөв бүрдүүлнэ.

7.2. Багийн шийдвэрийг хүндэтгэж харьцах ба хэрэв хууль бус, дүрэм журам зөрчсөн үйлдэл гарсан тохиолдолд байгууллагын захиргаанд баримт нотолгоотойгоор асуудлыг тавьж, шийдвэрлүүлнэ.

7.3. Шалгаруулалтад орж буй иргэд өөрийн чадвар боломжгүйгээс болж оноо хүрээгүй хирнээ бусдад бурууг нялзаах, хов живийн чанартай яриа гаргахыг Нэгдсэн эмнэлгийн захиргаа хүлээн зөвшөөрөхгүй.

7.4. Сонгон шалгаруулалтын шалгалтын дүнг зарласнаас хойш 24 цагийн дотор шийдвэрлүүлнэ. Энэ хугацааг өнгөрснөөс хойш тухайн шалгалттай холбоотой иргэний гомдлыг хүлээн авахгүй.

8. Бусад


8.1 Сонгон шалгаруулалтад орох иргэн дараах хуулийг судалсан байх:

- Эрүүл мэндийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Эмнэлгийн тусламжийн тухай хууль
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

БОЛОВСРУУЛСАН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН

 Г.ТАМИРАА

ХЯНАСАН:
УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТ САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАЯРБААТАР